

**МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛЭЭС**

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМАНД

Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн хуралдааны 13 дугаар тэмдэглэлд:

"ХХҮ.3. Монгол Улсын 2013 оны төсвийн тухайн хуульд заасан өмнөх онуудад баригдсан авто замын үнийн зөрүүний талаар Зам, тээврийн сайд А.Гансүх Засгийн газрын хуралдаанд танилцуулав. Үүнтэй холбогдуулан:

3.1. Монгол Улсын 2013 оны Төсвийн тухай хуулийн Зам, тээврийн сайдын багцад өмнөх онуудад баригдсан авто замын үнийн зөрүүнд олгохоор тусгагдсан 45.5 тэрбум төгрөгийг Улсын Их Хурлаар хэлэлцсэн нэр бүхий аж ахуйн нэгж, байгууллагуудад хуваарилах нь зүйтэй гэж үзэв.

3.2. Цаашид авто замын барилгын ажлыг үнийн зөрүү гаргахгүйгээр гүйцэтгүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Зам, тээврийн сайд А.Гансүхэд даалгав." гэжээ.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР